

Монгол Улсын Ерөнхийлөгчийн

2018 оны 1 дүгээр сарын 31-ний

өдрийн 09 дүгээр зарлигийн

хоёрдугаар хавсралт

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ДАЛБААНЫ

ЗАГВАР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Прокурорын байгууллагын далбаа нь тус байгууллагыг нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага болохын агуулгыг илэрхийлнэ.

1.2. Прокурорын байгууллагын далбааг энэ журамд заасны дагуу хэрэглэнэ.

Хоёр. Прокурорын байгууллагын далбааны загвар

2.1. Прокурорын байгууллагын далбаа нь мөнх хөх тэнгэрийг билэгдсэн өнгөтэй, төв хэсэгт нь прокурорын байгууллагын бэлэгдэл байх ба өргөн, урт нь 1:2 хэмжээний харьцаатай байна.

2.2. Прокурорын байгууллагын далбаа нь дор дурдсан загвартай байна.



Гурав. Прокурорын байгууллагын далбааг хэрэглэх журам

3.1. Прокурорын байгууллагын далбааны эх загварыг Улсын Ерөнхий прокурорын албан өрөөнд байрлуулна.

3.2. Прокурорын байгууллагын далбааг дор дурдсан газар, зүйлд байрлуулж, хэрэглэнэ.

3.2.1. дээд шатны прокурорын албан өрөө;

3.2.2. прокурорын газруудын хурал, зөвлөгөөн, хүндэтгэл, уулзалтын танхим, албан байрны гадна талд байрлуулсан тусгайлсан иш;

3.2.2. прокурор, ажилтнуудын оролцсон албан ёсны ажил, арга хэмжээ, уралдаан, тэмцээн.

3.3. Прокурорын шат шатны байгууллагууд нь цэвэр үзэмжтэй, батлагдсан загвар бүхий прокурорын далбааг хэрэглэнэ.

Дөрөв. Бусад

4.1. Прокурорын шат шатны байгууллага, прокурор, ажилтан нь прокурорын байгууллагын далбаанд хүндэтгэлтэй хандаж хэрэглэнэ.

4.2. Прокурорын байгууллагын далбааны загварыг өөрчилж хэрэглэхийг хориглоно.

4.3. Прокурорын байгууллагын далбааг албан үйл ажиллагаанд хэрэглэнэ.

4.4. Энэ журмын хэрэгжилтэнд Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газар хяналт тавьж ажиллана.

---oO---